



**НИЙСЛЭЛИЙН  
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар М/10

Улаанбаатар хот

Байгууллагын дэргэд “Залуучуудын хөгжлийн зөвлөл” байгуулах тухай

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаал, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоол, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Тэргүүн:

Үйлдвэрлэл, технологийн албаны

Ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Үйлдвэрлэл, технологийн кластер инженер

Жолооч


2. “Залуучуудын хөгжлийн зөвлөлийн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

3. Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг Зөвлөл (Б.Мөнгөнхуяг)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН



## БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь Залуучуудын хөгжлийн зөвлөлийн цаашид ЗХЗ гэх үндсэн зорилго, чиг үүрэг, үйл ажиллагаанд баримтлах зарчим, удирдлага зохион байгуулалт, хариуцлага тэдгээртэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. ЗХЗ нь байгууллагын залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих орон тооны бус зөвлөл байна.

1.3. ЗХЗ нь зохион байгуулалт үйл ажиллагаандаа энэхүү дүрмийг мөрдлөг болгох бөгөөд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, үндэсний хөтөлбөр, холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.

1.4. Залуучуудын хөгжлийн зөвлөлийн оноосон нэр:

1.4.1. Монгол хэлээр: Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн Залуучуудын хөгжлийн зөвлөл

1.4.2. Англи хэлээр: Youth development council, Baganaur industrial technology park

### Хоёр. Эрхэм зорилго, алсын хараа

2.1. Алсын хараа: Залуучуудын “Аз жаргал”-тай ирээдүйн төлөө

2.2. Эрхэм зорилго: Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих замаар залуучуудын үнэлэмж, өрсөлдөх, чадварыг нэмэгдүүлэхэд энэхүү зөвлөлийн зорилго оршино.

### Гурав. Баримтлах зарчим

3.1. ЗХЗ нь дараах зарчмыг баримтална:

3.1.1. Хүний эрх, хуульт ёсыг дээдлэх;

3.1.2. Бусдыг сонсох, ялгаварлан гадуурхахгүй байх;

3.1.3. Ил тод нээлттэй байх;

3.1.4. Тэгш эрхтэй байх;

3.1.5. Залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, эерэг хандлагатай байх;

3.1.6. Залуучуудын санал, санаачлага, сайн дурын үйл ажиллагааг дэмжих;

- 3.1.7. Шинийг санаачлагч байх;
- 3.1.8. Идэвхитэй хамтрагч, оролцогч байх;
- 3.1.9. Өрсөлдөх чадвараа хөгжүүлэх;
- 3.1.10. Хариуцлагатай, шударга, эх оронч үзэлтэй байх;

#### Дөрөв. Үндсэн чиг үүрэг

4.1. Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих, биелэлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хамтран ажиллах, хяналт тавих, хэрэгжилтийг хангах;

4.2. Залуучуудын өмнө тулгамдаж буй аливаа асуудлаар хэлэлцүүлэг, хурал, зөвлөгөөнөөр хэлэлцэж гарсан санал санаачлагыг уламжлах, төлөөлөх, холбогдох газарт хүргэх;

4.3. Залуучуудын сайн дурын үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах, сурталчлах;

4.3. Залуучуудын хөгжлийн төв, сонирхлын клуб, дугуйлан, зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах;

4.3. Зорилтот бүлгийн залуучуудад дэмжлэг үзүүлж ажиллах, санаачлах;

#### Тав. Бүтэц, зохион байгуулалт

5.1. Хамт олны хурлаар ЗХЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг сонгох, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, тайлан илтгэлийг сонсох, хэлэлцэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна.

5.2. ЗХЗ-ийн тэргүүн дараах эрхийг хэрэгжүүлнэ.

5.2.1. ЗХЗ-ийн гишүүдэд ажил үүргийг хуваарилан хариуцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавих

5.2.2. ЗХЗ-ийн хурлыг зохион байгуулж, хамт олны хуралд ЗХЗ-ийн ажлыг тайлагнах, гишүүдийг нэр дэвшүүлэх, чөлөөлөх саналыг оруулах

5.3. ЗХЗ-ийн гишүүн нь дараах эрхийг хэрэгжүүлнэ.

5.3.1. ЗХЗ-ийн хуралд хэлэлцэх асуудлаар санал өгөх

5.3.2. ЗХЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцох

5.3.3. Хариуцсан ажлаа үр дүнтэй гүйцэтгэх

5.3.4. ЗХЗ-ийн Тэргүүнийг сонгож чөлөөлөхөд санал өгөх

#### Зургаа. Үүрэг, хариуцлага

6.1. ЗХЗ нь залуучуудын эрх, хөгжил, оролцоог хангахтай холбоотой асуудлаар санал, санаачлага гаргаж, тухайн бүс нутаг салбар дахь бодлого, хөтөлбөрт залуучуудын хөгжих орчин нөхцөл, аж байдлыг сайжруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг тусгуулахад санал гаргах, хэрэгжилтийг дэмжих;

6.2. Залуучууд хөгжлийн үндэсний болон салбар зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа уялдуулан төлөвлөгөө гаргах, үр дүнгийн талаар хэлэлцэж, биелэлтийг жил бүр удирдлагад танилцуулж, хэрэгжилтийн тайланг холбогдох шатны зөвлөл, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

6.3. ЗХЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллага, олон улсын байгууллагын өгсөн хандив, тусламж, санхүүгийн дэмжлэгийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтнууд нь өөрийн дансаар болон өөр этгээдийн дансаар хүлээн авч зарцуулахыг хориглоно.

Долоо. Зөвлөлийн үйл ажиллагаанд хориглох зүйл

7.1. Зөвлөлийн үйл ажиллагаанд улс төр нам, эвсэл, шашны үйл ажиллагааг сурталчлах;

7.2. Аливаа байгууллагын болон хувь хүний нэр хүндэд халдах, гүтгэх, гутаан доромжлох;

7.3. Ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулах;

**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН ДАРХЛААЖУУЛАЛТАД  
ХАМРАГДСАН БАЙДАЛ**

2021 оны 11 сарын 15-ны өдөр

Багануур дүүрэг

№	Ажилтан, албан хаагчын овог нэр	регистр	Дархлаажуулалтад хамрагдсан байдал			Хамрагдаагүй шалтгаан
			1 тун	2 тун	3 тун	
1	Ч.Элбэгсайхан	УЮ65100611	+	+	-	Сэргээх эмчилгээ дууссаны дараа хийлгэнэ.
2	Л.Оюунцэцэг	СЧ63080163	+	-	-	Вакцинаас харшилсан. Эмчийн заалтаар хийлгээгүй.
3	С.Отгонбаатар	УЮ60120317	+	+	+	
4	Э.Энхзаяа	УЮ93022226	+	+	+	
5	М.Мөнхдулам	УГ73011000	+	+	-	Харшилтай
6	Б.Зоригт	ХВ81080276	+	+	-	60 хоногийн дараа хийлгэх эмчийн заалттай.
7	Б.Мөнгөнхуяг	НЧ92041911	+	+	-	Бүрэн эдгэрсний дараа хийлгэнэ.
8	Ч.Баярцэцэг	ТГ85061105	+	+	-	Харшилтай
9	Б.Мөнхтуяа	УМ89032001	+	+	-	Спутник 2 тун хийлгэсэн тул 3 дахь тун тариулах шаардлагагүй гэж эмч хэлсэн.
10	Д.Бат-Эрдэнэ	СР91021818	+	+	+	
Нийт						

СУДАЛГАА ГАРГАСАН:  
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Э. Энхзаяа* Э.ЭНХЗАЯА